

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255005>

КАЗАХ ХҮНИЙ НЭР БА СОЁЛ СУДЛАЛЫН АСУУДАЛ

Б.Даваасүрэн

Аннотация: В настоящее время ономастика является одним из актуальных вопросов лингвистики, поскольку представляет собой важный пласт лексики любого языка. В данной статье мы рассмотрели антропониимику казахов. Само исследование может стать ключевым для осознания менталитета и специфики мышления кочевой цивилизации, но и, более того, подобные исследования станут важным толчком при решении вопросов исторического развития языка в области фонетики, лексикологии, морфем, заимствований.

Түлхүүр үг: угсаатны хэл шинжлэл, шашин зан үйл, хүний нэр, казах хүний сэтгэлгээ, нүүдлийн соёл, соёл судлал.

Хүний нэр судлал нь түүх, шашин мөргөл, хүн судлал, угсаатны зүй, ёс заншил, зан үйл гэх зэрэг соёлын өргөн хүрээг хамарсан онцлогтой нарийн судалгаа юм.

Туулж ирсэн үүх түүхтэй, бие даасан үндэстэн бүрийн ахуй ёс, зан заншлаас төрж гарсан өвөрмөц сэтгэлгээ нь оноосон нэрийн зүйлд шингэж улмаар хойч үеэрээ дамжин дараа дараагийн үедээ уламжлагдан үлддэг. Он жил өнгөрөх тусам хүний нэрийн зүйлд шингэж үлдсэн үндэстэн, ард түмний ертөнцийг үзэх үзэл, бусад үндэстнээс ялгарах ялгаа, олон мянган жилийн туршид бие дааж хөгжиж боловсорч ирсэн сэтгэлгээ бүдгэрч, буруу зөрүүтэй тайлбар хийх, алдаатай ухаарах, мартагдах зэрэг сөрөг үзэгдэл бий болох нь олонтоо. Тиймээс *антропонимика* буюу хүний нэрийн судлалыг хөгжүүлснээр язгуурын соёлоо (энд *соёл* гэдгийг дээр дурдсан бүхий л талыг багтаасан өргөн утгаар хэрэглэв) сэргээх, хадгалж үлдээх, хойч үедээ уламжлуулан өвлүүлэх асуудал хамт шийдэгддэг гэдгийг онцлон дурдмаар байна.

Үүнээ монгол хүний нэр мөн л адил олон мянган жилийг туулж ирсэн өөрийн гэсэн бүхэл бүтэн сонин содон ертөнц мөн. Казах хүний нэр энэ ертөнцийн басхүү нэгэн салшгүй хэсэг нь болж ирсэн билээ. Нүүдлийн соёлтой ард түмний хувьд ахуй соёл, сэтгэлгээ, зан заншил, хэлний гарлын хувьд адил ба адил төстэй шинжүүд нэлээдгүй байдаг. Нөгөө талын шашин шүтлэг, зан суртал, сэтгэлгээний талаар хоорондоо адилгүй талууд байдаг хэдий ч монгол, казах хэл гарлын хувьд төрөл хэлнүүд учир сэтгэлгээний нийтлэгээс гадна басхүү соёл судлалын хүрээнд нийтлэг зүйл байдаг тул монгол хүний нэрийн зүйлтэй харьцуулж үзэх нь тухайн сэдвийг өргөн хүрээнд харж дүгнэх боломжийг олгоно.

Бид энэхүү өгүүллийн хүрээнд казах хүний нэрийн тухай соёл судлалын талаас авч үзэхийг зорьсон болно. Чингэхдээ ерөөс аливаа үндэстэн, ард түмний хэл соёл, угсаа түүхийн судлаач хүнээс тухайн салбар ухаан, сэдвээ гадарладаг төдий бус доторлодог байхыг шаардах нь зүйн хэрэг бөгөөд чухам ийм босгыг давж байж тэрхүү ертөнцийг зөв ухаарч, үнэн бодитоор дэлгэн үзүүлэх боломж нээгддэг.

Казах хүний нэрийн судлал XX зууны хоёрдугаар хагасаас эхэлж эрчимтэй хөгжсөөр өнөөг хүрч улмаар судалгаа шинжилгээний ажлын цар хүрээгээ тэлж, судлах арга барил нь боловсронгуй болсоор байна. Үүнд, Т.Ж.Жанузаков, О.А.Султаньяев, К.Есбаева, Е.А.Керимбаев, С.А.Рахымберлина, А.Ж.Аметова, К.Рысберген зэрэг эрдэмтдийн судалгаа, шинжилгээний бүтээлүүд казах хүний нэрийн судлалд чухал байр суурь эзэлдэг.

Казах ард түмний уламжлал ёсоор дөнгөж төрсөн хүүхдэд өвөө нь эсвэл олноо хүндтэй нэгэн нэр хайрладаг ёстой. Энэ нь хожим хүүхэд нь нэр хайрласан өвөө шигээ эсвэл тэрхүү түмэнд хүндтэй хүн шиг болж өсөх болтугай гэдгийг бэлгэддэг. Казах нэрийн талаар үүнтэй холбогдуулж П.А.Мухтаровна: *«Считалось, что сглаз на девочек не действует так сильно, как на мальчиков, и для них выбирались самые красивые и нежные имена. Часто в качестве имени давались названия дорогих материй: Жибек (шелк); нежных растений: Раушан (роза), Кызгалдак (тюльпан), Енлик (эдельвейс); драгоценных металлов и камней: Алтын (золото), Кумис (серебро), Гаухар (изумруд), Маржан (жемчуг). Чтобы девочки росли красивыми, их называли именами небесных светил: Кунсулу (красивая как солнце), Айсулу и Айгуль (красивая как луна, лунолика), Шолпан (утренняя звезда)»* хэмээн тэмдэглэсэн байдаг. Үүнээс харахад казах ард түмэн дөнгөж төрсөн хүүхдэдээ нэр хайрлахдаа онцгой анхаарч, хүүхдийн нэр тухайн хүүхдийн ирээдүйн хувь заяанд нь нөлөөлдөг хэмээн үзсээр иржээ.

Казах хүний нэрийг утга агуулгаар нь ангилан үзвэл:

Монголд бурхны шашин дэлгэрсэн цагаас хойш төвөд, санскрит гаралтай шашин мөргөлийн утгатай нэрийн зүйлийг хүний оноосон нэрээр хэрэглэх болсон уламжлал эдүгээ мэдэгдэм саарсан хэдий ч оршсоор байгаа. Жишээлбэл, монгол хүний нэрд **Санжай** (төв. *ᠰᠠᠩᠵᠠᠢᠵᠠᠰ* *sangs rgyas*) – *Бурхан*; **Гэндэн** (төв. *ᠭᠡᠨᠳᠡᠨ* *dge 'dun*) – *Хувраг*; **Чой** (төв. *ᠴᠣᠢ* *chos*) – *Ном* гэх мэт төвөд гаралтай, **Дарма** (сан. *धर्म* *dharma*) – *Ном*; **Ананд** (сан. *आनन्द* *Ānanda*) – *Ананд* (Бурхан багшийн дотно арван шавийн нэгний нэр) санскрит гаралтай нэр нийтлэг байдгийг бид мэднэ. Тэгвэл үүний нэгэн адил казах хүний нэрд:

1. Исламын шашинтай холбоо бүхий хүний нэр.

Исламын шашинд цэвэр ариун, биширч хүндэлбэл зохих ёстой хэмээн үздэг зүйлийг шууд эсвэл бэлгэдэж хүний нэр болгон хайрласан байдаг.

Жишээлбэл, **Абдилгажи** - ар. *عبد* (*abd*) – *(Аллахын) үнэнч боол*; ар. *حاج* (*haji*) *Меккед мөргөл үйлдсэн*; **Ахытхажы** - ар. *أحد* (*ahad*) – *Цорын ганц*; ар. *حاج* (*haji*) *Меккед мөргөл үйлдсэн* гэх мэт хүний нэрд орсон *гажи*, *хажы* (араб. *حجة*) нь мөргөл үйлдэх, даяанчлах гэсэн утгатай үг. Мусульманчууд Мекка хотод очиж *хаж*а үйлддэг учир тус хот исламын шашинтай хүний хувьд ариун дагшин хот төдийгүй 570 гаруй жилийн өмнө Мекка хотод исламыг үндэслэгч Мухаммад (араб. *مُحَمَّد*) төрсөн, мусульманчуудын ариун шүтээн Кааба (араб. *الكعبة المشرفة*) байдаг зэргээс үүдэж ийнхүү хүүхдэдээ нэр хайрлахдаа нэрд нь багтаадаг байна.

Түүнчлэн **Ашим** - ар. *هاشم* (*hashem*) – *Мөргөлчдөд талх түгээгч*; **Алхам** - ар. *إِلْهَام* (*ilham*) – *Урамшил, бурхан тэнгэрийг магтмуй*; **Аятхан** - ар. *آيات* (*ayat*) – *Коран судрын аят*; мо. (*qan*) *Хан*; **Амангажи** - ар. *أمان* (*aman*) – *Эрүүл энх, үл гэмтэх*; ар. *حاج* (*haji*) *Меккед мөргөл үйлдсэн*; **Амарберген** - ар. *عمر* (*eumr*) – *Урт настай*; каз. (берген) *Бурхан өгсөн*; **Айжанат** - 1. каз. (ай) – *Сар*; каз. (жан) гэдгээс үүссэн нэр

Сэтгэл; 2. каз. (ай) *Сар*; ар. الجنة (al-janeh) *Энхжиний орон, диваажин* гэх мэт хүний нэрээс исламын шашин, ариун коран судар, буян хийх, бурхны буян хишиг гэсэн шашин мөргөлийн утга агуулга тодорхой харагдана. Жишээлбэл, **Бибатима** - түр. (bey) – *Эзэн, эмир; баян хүн*; ар. فاطمة (fatima) *Эхийнх нь хөхнөөс хүчээр гаргасан* хэмээх нэрд орсон *Батима* буюу *Фатима* гэх нэрийн утга учрыг товч төдий дурдвас. Энэ нэр бол Мухаммедын охины нэр бөгөөд бага балчир настай байхад нь эхээс нь салгасан учир ийнхүү нэрлэх болсон гэдэг. Мөн *Фатима* гэдгийг *гэгээн дүртэй* хэмээн орчуулах нь ч бий. Учир нь Фатима-г түүхийн судар бичигт маш энэрэнгүй, тусархуу, шударга үнэнч зантай хэмээн тэмдэглэж үлдээсэн байдаг.

Аргынгазы - каз. (аргын) – *Аргын овгийн*; ар. غازي (ghazy) *Газаватад оролцогч*. Энэхүү нэрд орсон *Газы* буюу *Газават* гэдэг нь буруу номтны буюу *кафир* (араб. كافر *kāfirūn* «буруу номтон»)–ын эсрэг хийх ариун дайн гэсэн утгатай үг. Энэ нь Бурханы шашинд Шамбалын дайн. Загалмайтны шашинд Антихрист буюу и Апокалипсис хэмээх ирээдүйд болох үйл явдалтай адил ойлголт юм.

Исламын он тоолол, од гараг эрхэстэй холбоо бүхий хүний нэр.

Монгол хүний нэрийн зүйлд төвөд, санскрит хэлний өдөр, сартай холбоотой нэр байх нь элбэг. Жишээлбэл, **Даваасүрэн** (төв. *ᠳᠠᠪᠠᠰᠦᠷᠦᠨ zla ba srung*) – *Сар сахигч; Даваажав* (төв. *ᠳᠠᠪᠠᠵᠠᠸᠠᠭ zla ba skyabs*) – *Саран аврал; Мягмар* (төв. *ᠮᠢᠭᠠᠮᠠᠷ mig dmar*) – *Улаан нүдэн гараг* буюу *хоёр дахь өдрийн нэр; Сумьяа* (санс. *sōtavāras*) – *Нэг дэх өдөр* (Сумьяа гараг); **Буд** (санс. *budhavāras*) – *Гурав дахь өдөр* (Буд гараг) гэх мэт. Монголчуудын хүүхдэдээ нэр хайрлах ёсонд долоо хоногийн төрсөн өдрөөр нь нэрлэх тохиолдол одоо ч хэвээр байна. Казах хүний нэрд бас үүнтэй адил ёс байна.

Ережеп - түр. (er) – *Эр хүн; баатар зоригтой*; ар. رجب (rajab) *Раджаб сард төрсөн*. Раджаб сар бол хижрагийн тооллоор долоодугаар сар бөгөөд дайн дажин хийх хориотой дөрвөн сарын нэгийн нэр. Мөн ариун Рамадан сарын өмнөх сар.

Ауелде - ар. أول (ola) – *Анхдагч, эхлэгч*; пер. دی (de) *Хиджрагийн тооллын Дей сар* буюу *аравдугаар сард төрсөн*. Дей сар бол хижрагийн тооллын өвлийн эхэн сарын нэр. Григорианы тооллоор 12 сарын 22 өдрөөс 1 сарын 20 өдөр хүртэлх хугацаа буюу монгол он цагийн тооллоор ес эхэлдэг өдөр.

Айшолпан - ка. (ай). Сар; тү. (çulpan). Өглөөний од, цолмон гараг; **Айжулдыз** - ка. (ай). Сар; ка. (жүлдыз). Од; **Алтынжүлдыз** - ка. (алтын). Алт; ка. (жүлдыз). Од.

Энэ мэтчилэн казах хүний нэрд **Бейсенгари** - 1. каз. (бейсен) – *Дөрөв дэх өдөр төрсөн*; ар. قاري (qari) *Коран судар уншигч, Коран судрыг цээжээр мэдэгч*; 2. каз. (бейсен) *Дөрөв дэх өдөр төрсөн*; пер. كاري (khari) *Ажилсаг хичээнгүй*; **Дүйсен** - каз. (дулату) – *Нэг дэх өдөр төрсөн*; **Атина** - пер. أدينا (dina) – *Баяр ёслол, тав дахь өдөр*; **Базарбек** - пер. بازار (bazar) – *Баяр, тав дахь өдөр*; түр. (бек) *Ноён, удирдагч*; **Есет / Асе / Асет** - 2. ар. الأسد (al-asad) – *Долоон сард төрсөн* хэмээн сар, өдөр, од эрхсийн нэрийг хүүхдэдээ нэр болгон хайрлах нь олонтоо байдаг. Мөн казах, монгол од эрхсийн нэрийг хамтатган өгсөн байх нь бас бий. Жишээлбэл: каз. **Айжайнар** - ка. (ай). Сар; ка. (жай). Аянга; мо. (naran). Нар.

2. **Уул ус, булаг шанд, мод цэцэн гэх мэт байгаль дэлхийтэй холбоо бүхий хүний нэр.**

Амирмуса - ар. أمير (amir) *Хаан, эзэн*; ар. موسى (musaa) *Уснаас гаргаж авсан*. Египетийн хааны зарлигаар дөнгөж төрсөн бүх еврей хүүхдийг цаазлах зарлиг гаргасан жил Моисей мэндэлсэн хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Моисейн

эх Иоховеда хүүгээ гурван сарын турш бусдаас нууж чадсан хэдий ч цаашид боломжгүй болсон учир нишингээр сагс сүлжиж, давирхай түрхээд түүн дотор Моисейг хийгээд Нил мөрөнд урсгажээ. Нил мөрнөөр урсаж явсан Моисейг хааны гүнж олж өөрийн хүүхэд мэт асарсан гэсэн түүхтэй. Энэ домог түүх бол «*Лу. Алтан товчи*»-д гардаг Төвөдийн Хүзүүн сандалт хааны домогтой их л төстэй. «*Лу. Алтан товчи*»-д тэмдэглэсэнээр: «*enedkeg-ün makada-yin küšala qayan-u köbegün sarba neretü qayan-u tabun köbegün-ü odyan inu törülki kiris üsütü yar köl inu qabtaqai nidün inu दौरа-аа дегегсиде анику буу. ене уридаки төрүл-түр адали бусу кемелдүжү жис қақурцаг-тур кижү канга мөрен-түр оқурбай. балбу төбед қояр-ун жабсар-а төбед-үн ниген ебүген мөрен-ү кияқар-аа қақурцаг-и олуқад негежү үјебесү қоу-а үјесгүлентү ниген көбегүн ажуқи*». Түүнчлэн монгол хүний нэрд Бадамжунай (төв. *ᠪᠠᠳᠠᠮᠵᠣᠨᠠᠢ* *bad ma 'byung gnas*) – *Уснаас гарсан, төрсөн хэмээх төвөд гаралтай нэр бий*. Энэ нь мөн л Ловон Бадамжунайг лянхуа цэцгээс хувилж төрсөн гэж үздэг учир ийнхүү нэрийдсэн хэмээх домогтой холбоотой.

Энэ мэтчилэн казах хүний нэрд уул чулуу, гол горхи, цэцэг модны нэршилтэй холбоотой нэр байх нь нийтлэг. Жишээлбэл, **Амандаг**- ар. *أمان* (aman) – *Эрүүл энх, үл гэмтэх*; түр. (dağ) *Уул, уулын*; **Арафат** - ар. *عرفات* (earafat) *Ариун уул*; **Алтынтас** - каз. (алтын) *Алт*; каз. (тас) *Чулуу*; **Акмеруерт** - каз. (ак) *Цагаан*; *гэгээлэг*; *цэвэр ариун*; *буурал*; гер. *Margaritis* (margaritis) *Сүвд*; **Айбулах** - каз. (ай) *Сар*; каз. (бүлак) *Булаг*; **Акдари** - каз. (ак) *Цагаан*; *гэгээлэг*; *цэвэр ариун*; *буурал*; пер. *دریا* (darya) *Тэнгис, гол мөрөн, орд харишид амьдрагч*; **Акжайык** - каз. (ак) *Цагаан*; *гэгээлэг*; *цэвэр ариун*; *буурал*; каз. (жайык) *Урал голын казах нэр*; **Аузан** - пе. *أبو* (abu). *Аав, эцэг*; пе. *زان* (zan). *Царс мод*; **Гүлнар** - 1. пе. *گل* (gol). *Цэцэг*; ар. *أنار* (anar). *Гал, туяарсан, гэрэлтүүлэгч*; 2. пе. *گل* (gol). *Цэцэг*; пе. *أنار* (anar). *Анар жимсний мод*; **Ёлкабек** - ор. (ёлка). *Гацуур мод*; тү. (бек). *Ноён, удирдагч*;

3. Энхрийлэн сайн сайхныг бэлгэдсэн утга бүхий хүний нэр.

Монголчуудын нэр хайрлах ёсонд айлын хэд дэх хүүхэд болохоор нь нэр өгөх ёс байдагтай адил казах хүний нэрийг үзвээс мөн *нялх, ахмад, ууган, том, отгон, хүсэн хүлээсэн* гэх мэт үг багтсан нэр элбэг байдаг. Гэхдээ энэ мэт утга бүхий нэр нь перс, түрэг, араб хэлнээс гаралтай үг байх нь нийтлэг. Жишээлбэл, **Балбөбек** - түр. (бал). *Бал*; пер. *بابک* (babak). *Нялх хүүхэд*; **Баглан** - пер. *باغلان* (baghlan) *Том, ахмад*; **Асхар** - ар. *أصيل* (asghar) *Отгон хүү*; **Ашир** - ар. *عاشر* (ashir) *Арав дахь хүүхэд*; **Алдан** - каз. (алдан) *Тэргүүнд зогсогч, ууган хүүхэд*; **Адилмурат** - ар. *عادل* (adel) *Шударга, итгэлт*; пер. *مراد* (morad) *Хүсэн хүлээсэн*; **Аймурат** - каз. (ай) *Сар*; пер. *مراد* (morad) *Хүсэн хүлээсэн*; **Алимурат** - ар. *علي* (ola) *Эрхэм хүндэт*; пер. *مراد* (morad) *Хүсэн хүлээсэн*; **Гүлжанар** - пер. *گل* (gol) *Цэцэг*; каз. (жанар) *Мэлмий, гэрэлтсэн нүдтэй*.

Түүнчлэн үр хүүхдийнхээ ирээдүйн сайн сайхныг бэлгэдэж, ерөөсөн утгатай нэр хайрлах нь олонтоо. Үүнд, *улс орон, ард түмэндээ алдар нэр хүндтэй, үнэ цэнтэй, эелдэг даруу зан төлөвтэй* болохыг хүсэмжлэн бэлгэдсэн нэр. Мөн арвижин дэлгэрэхийг бэлгэдэж *мод, жимс, цэцгээр төлөөлүүлж нэрлэх, ан амьтны эд эрхтний нэрээр өхөөрдөн энхрийлэх* нь бас байдаг аж. Жишээ нь: **Гүлназ** - пер. *گل* (gol) *Цэцэг*; пер. *ناز* (naz) *Гунхсан, гунхалзсан; эелдэг; эелдэг*; **Байтуган** - түр. (bey) *Эзэн, эмир; баян хүн*; каз. (туған) *Ураг төрөл, ах дүү*; **Гүлзада** - пер. *گل* (gol) *Цэцэг*; пер. *زاده* (zadeh) *Хүүхэд, хүү, өв залгамжлагч*; **Бегзат** - түр. (бек) *Ноён, удирдагч*; пе. *زاده* (zadeh) *Хүүхэд, хүү, өв залгамжлагч*; **Гүлшахира** - пер. *گل* (gol) *Цэцэг*; ар. *شيرة* (shahira) *Алдартай, нэр хүндтэй*; **Гүлманат** - пер. *گل* (gol) *Цэцэг*; каз. (манат) *Үнэ цэнтэй*; **Гүлнар** - 1. пер. *گل* (gol) *Цэцэг*; ар. *أنار* (anar) *Гал,*

туяарсан, гэрэлтүүлэгч; 2. пер. گل (gol) Цэцэг; пер. أنار (anar) Анар жимсний мод; **Гүлсара** - 1. пер. گل (gol) Цэцэг; пер. سره (sareh) Цэвэр ариун; ариун шударга; 2. пер. گل (gol) Цэцэг; ар. سار (sar) Таашаал; баяр баясгалан; **Аякөз** - каз. (ай) Сар; каз. (көз) Нүд; **Ботагөз** - каз. (бота) Ботго; каз. (көз) Нүд; **Гайны** - 1. ар. العيني (al-aini) Жинхэнэ; 2. ар. عيني (aini) Нүд; **Дилдагүл** - пер. دل (dell) Зүрх сэтгэл; ухаан; пер. گل (gol) Цэцэг; **Замира** - 1. ар. ضامر (dhamer) Гуалиг; ер бусын; 2. пер. ضمير (zameer) Зүрх сэтгэл; **Актулпар** - каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; каз. (түлпар) Далавчтай морь, байлдааны хүлэг морь.

4. Ан амьтнаар төлөөлүүлсэн хүний нэр.

Эртний хүмүүсийн зан үйл, ахуй ёс, сэтгэлгээтэй холбоотой буюу тэрхүү цаг үеэс үлдэж өвлөгдсөн сэтгэлгээ гэж үзэж болох юм. Учир нь эртний овог аймаг үүсэн бүрэлдэж байсан цаг үед байгалийн үзэгдэл, ан амьтан жигүүртнийг бишрэн шүтэх, амьдчилах, овог аймаг бүр өөрсдийгөө ямар нэгэн амьтнаас үүсэлтэй гэх итгэл үнэмшил нь тухайн ан араатан, жигүүртэн шувуу, ургамлыг шүтээн (тотемизм) болгосоор ирсэн байдаг. Нөгөө талын казахуудын эрт цагаас нааш эрхэлж ирсэн нүүдлийн мал аж ахуйтай буюу амьдрал амьжиргааных нь гол эх үүсвэр болсоор ирсэн таван хошуу малтай холбоотой. Монголчууд ч мөн адил үр хүүхдээ өхөөрдөхдөө *ботгон нүдтэй, миний унага, хурга шиг, ишиг шиг* гэх мэтээр өхөөрдөж адилтган дуудах нь бий. Казах хүний нэрд таван хошуу малын үр төлөөр **Байкозы** - түр. (bey) Эзэн, эмир; баян хүн; каз. (kozy) Хурга; **Алтынтайлак** - каз. (алтын) Алт; каз. (тайлак) Тайлаг (хоёр настай ботго); **Айбота** - каз. (ай) Сар; каз. (бота) Ботго; **Амантай** - ар. أمان (aman) Эрүүл энх, үл гэмтэх; түр. (tay) Унага; **Байтел** - түр. (bey) Эзэн, эмир; баян хүн; каз. (тел) Тэлээ хурга хэмээн нэр өгөх нь бий.

Мөн таван хошуу малын эцэг малын нэршлээр **Бүка** - каз. (бүка) Бух; **Ахбуршахка** - (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; каз. (бура) Буур; пер. شاه (shah) Хаан; **Бурахасын** - ка. (бура). Буур; ар. حصين (husain). Хүчтэй, үл дийлдэх.

Түүнчлэн хүч чадал, цэвэр ариуны бэлгэдлийн илэрхийлэл болдог ан араатан, шувуу гэх зэрэг амьтны нэршлээр нэрлэсэн байдаг. Жишээлбэл, **Аккулан** - каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; каз. (күлан) Хулан; **Балапан** - каз. (балапан) Дэгдээхэй; **Акбалапан** - каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; каз. (балапан) Дэгдээхэй; **Акку** - 1. каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; каз. (күс) Шувуу; 2. каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; каз. (ку) Хун шувуу; **Аксункар** - каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; каз. (сүңкар) Шонхор; **Кушкан** - пер. قوش (qush) Шонхор; каз. (қан) Цус; **Актуйгын** - каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; каз. (түйгын) Харцага; **Актоты** - каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; пер. طوطى (toti) Тоть шувуу; **Акжүнис** - каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; ар. يونس (jons) Тагтаа;

Акказ - каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; каз. (каз) Галуу; **Асланбек**, **Асылан**, **Берлан**, **Ерлан**, **Абдулан** - түр. aslan гэдгийн (lan) Арслан; зоригтой; түр. (бек) Ноён, удирдагч; **Аккоян** - каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; каз. (коян) Туулай; **Актышхан** - каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; каз. (тышкан) Хулгана; **Аккундыз** - каз. (ак) Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; каз. (күндыз) Минж; аз жаргал минь, итгэл найдвар минь (хэмээн бага насны хүүхдийг өхөөрдөн дуудах үг); **Барыс** - каз. (барыс) Ирвэс; **Байбөри** - түр. (bey) Эзэн, эмир; баян хүн; каз. (бөрі) Чоно; **Дубай** - ар. دبي (dbi) Царцаахай (гэдэг үгийн багасгасан, өхөөрдсөн хэлбэр). Дубай хотын нэр хэрхэн үүссэн талаар олон янзын таамаг байдгийн нэг нь тухайн бүс нутагт царцайн нүүдэл дайрч өнгөрдөг байсантай холбож тайлбарладаг.

5. Элдэв муу явдал суудал, өвчин зовлон, үхэл хагацлаас хамгаалсан дом нэр.

Төрсөн хүүхэд нь тогтдоггүй айл дахин төрсөн нялх хүүхдэдээ **Токтар** - каз. (токтар) *Тогтож үлдэг*; **Елеусиз** - каз. (елеусиз) *Үзэгдэхгүй, үл өртөгч* (Муу зүйлээс хамгаалдаг дом нэр); **Турсын** - каз. (*түрсын*) *Амьд үлдэг*; **Журсын** - каз. (*жүрсын*) *Амьд үлдэг* гэх мэт дом нэр буюу хамгаалах нэр хайрладаг бол олон хүүхэдтэй **Жанилыс** - каз. (жаңыл гэдгээс үүссэн нэр) *Алдаа* (охин хүүхэдтэй айл дараагийн төрөх хүүхэд эрэгтэй байгаасай хэмээн бэлгэдсэн нэр); **Артык** - 1. каз. *Хамгийн сайн, үнэ цэнтэй*; 2. түр. *Илүү хүүхэд* (олон хүүхэдтэй айлд дахин хүүхэд төрөхөд хайрладаг дом нэр); **Тезек** – *Аргал, хоргол* (олон хүүхэдтэй айлд дахин хүүхэд төрөхөд хайрладаг дом нэр) эсвэл эрэгтэй хүүхэд хүссэн айл **Улбала** - каз. (*үл*) *эрэгтэй*; каз. (*бала*) *хүүхэд*; **Ултай** - каз. (*үл*) *эрэгтэй*; каз. (*тай*) *унага*. Түүнчлэн П.А.Мухтаровнагийн дурдсанчилан охин хүүхдийг бодвол эрэгтэй хүүхэд элдэв муу зүйлд өртөх нь амархан гэж үздэг учир бүстэй хүүхдэд үнэ цэнтэй эдийн нэр эсвэл цэцэг ургамалын нэр өгөх ёс байдаг аж. Жишээлбэл, **Жибек** - ка. (жібек). Торго, торгомсог; **Акжибек** - ка. (ак). Цагаан; гэгээлэг; цэвэр ариун; буурал; ка. (жібек). Торго, эелдэг зөөлөн; **Алтын** - ка. (алтын). Алт; **Кумис** - ка. (күміс). Мөнгө; **Маржан** - пер. (مرجان). Сувд; **Енлик** - ка. (енлік). Цагаан уул цэцэг гэх мэт нэр өгдөг ёстой аж.

Үүнээ онцлон тэмдэглэвээс монгол, казах хүний нэрийн зүйлийг авч үзвэл нүүдлийн аж ахуй, төрөл хэл, сэтгэлгээ, бэлгэдэлзүй зэрэг соёл судлал, хэлний талаараа адил төстэй нийтлэг зүйл илэрдэг бөгөөд энэ талаар цаашид судалгааны ажил гүнзгийрэх нь лавтай.

Дүгнэлт

Хүний нэр судлал нь аливаа хэлний үгийн утга бүдгэрэх, салаа утгатай болох, авианы олон янзын түүхэн үзэгдлийн зүй тогтлыг олох зэрэг үгийн сан судлалын нэгэн чухал хэсэг болдгийн хувьд маш чухал нарийн судалгаа юм. Үүнээ зөвхөн казах хүний нэрээр тогтохгүй монгол хүний нэрийн динамик хөгжлийг тодорхойлох, зүй тогтлыг илрүүлэх зэрэг олон талт ажил гэж үзэж болно.

Ном зүй

- Гульнара И.К. (2001). Антропономическая система современного казахского языка // Автореферат диссертации на соискание ученой степени доктора филологических наук. Казань 2001.
- Жанузак Т., Рысберген К. (2005). Исследование казахской ономастики // Ономастический вестник. № 2 (4) – С.3-13.
- Жанузакова Т. (1982). *Очерк казахской ономастики*. Алма-Ата.
- Жапова Д. Н. (2004). *Функциональная эволюция проприальной лексики (На материале антропонимии монгольских языков)*: Дис. канд. филол. наук : 10.02.22 : Улан-Удэ.
- Мухамедова З.Б. (1965). *Личная ономастика у туркмен // Питання ономастики*. – Киев,– С.151.
- Никонов В.А. (1974). *Имя и общество*. –М.: Наука,– С.17.
- Рахымберлина С.А., Аметова А.Ж. (2014). *Общественно-социальные основы неофициальных имён казахского языка*. Институт стратегических исследований.
- Раянди.Э. (1970). *Имя и право // Личные имена в прошлом, настоящем, будущем*. – М: Наука, – С.69.